



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/190

Хэрлэн сум

WEB SMS программд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.10 дахь заалт, аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хэмжээнд ус, цаг агаар, орчны аюултай болон гамшигт үзэгдлийн талаарх мээ мэдээллийг иргэдэд богино хугацаанд хүргэх үйл ажиллагаанд WEB SMS үйлчилгээг нэвтрүүлэх ажилд шаардагдах 7,865,000 (долоон сая найман зуун жаран таван мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Тооцоог хавсралтаар баталсугай.

3.Цахим программын аюулгүй найдвартай ажиллагааг хангах, иргэдийн үүрэн холбооны утасны дугаарыг нэгтгэн програмд оруулж багц мессэжийг иргэдэд хүргэх ажлыг чанартай зохион байгуулахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (Б.Хэрлэнчимэг)-д үүрэг болгосугай.

4.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр төрөл	Тоо	Нэг удаагийн үнэ	Иргэнд хүрэх тоо	Нийт	Давтамж	Нийт мөнгөн дүн
1	Мэссэж	1 удаа 1 иргэнд	55 төгрөг	11,000	605,000	13	7,865,000